



МОНГОЛ УЛСЫН  
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.7 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 60 дугаар тэмдэглэл, холбогдох яамд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өгсөн чиглэлийг тус тус үндэслэн Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. "Хөдөө аж ахуйн бирж" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс Ц.Баярмаа /Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны газрын дарга/, Н.Ганибал /Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны газрын дарга/, Э.Эрдэнэсүрэн /Эдийн засгийн хөгжлийн яамны хэлтсийн дарга/, Г.Хэрлэн /Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга/, Ц.Ариунсанаа /Сангийн яамны хэлтсийн дарга/, Л.Баатарчулуун /Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн/-ыг 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. "Хөдөө аж ахуйн бирж" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Л.Чой-Иш /Хүнс, хөдөө аж ахуйн яамны газрын дарга/, Б.Батцэцэг /Аж үйлдвэрийн яамны мэргэжилтэн/, Ш.Энх-Амар /Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн/, Д.Төгөлдөр /"Нью майнинг ресурс" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/, С.Тулга /Сангийн яамны мэргэжилтэн/, Х.Володя /Төрийн өмчийн хорооны ахлах мэргэжилтэн/ 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн томилсугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлагын газар /В.Дарханбаатар/-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.НАНЗАДДОРЖ

Ц.ОДМАА

Ц.ОДМАА

